*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Г.ЦЭРЭНЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | | Эхэлсэн, дууссан огноо: | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ "Нийгмийн даатгалын багц хууль болон бусад хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж нийгмийн даатгалын сангийн төсөв, түүний гүйцэтгэлд дотоод аудит хийж дүгнэлт зөвлөмж гарган хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах," ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| 1.1 | **Арга хэмжээ 1.1.** Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 16 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Хяналт шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | Шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг 5.0 хувиар нэмэгдүүлсэн байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. | 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 16 аж ахуйн нэгжээс 6 аж ахуйн нэгж үйл ажиллагаа зогссон 10 байгууллага шалгалтанд хамрагдсан. Авто агро ХХК нь шинэ ажилчдыг нийгмийн даатгалд хамруулаагүй зөрчилд 500,0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсныг барагдуулсан байна.<br>7 байгууллага нь нийт 49,9 сая төгрөгийн өр үүсгэснийг шалгалтын хугацаанд төлүүлсэн. Онхоодой өндөр ХХК нь 50,6 хувийн эрсдэлтэй 12 сая төгрөгийн өр төлөгдөөгүй тул дансыг хааж ажилласан. Нийт байгууллагын хууль сахин мөрдөлтийн хувь 53,4 хувь, эрсдэл 57,6 буюу өмнөх шалгалтаас 5,0 хувь өссөн байна.<br>Нийт зөрчил: ажилчдын ажилласан жилийг буруу тооцосон, хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилчдын код нэршлийг буруу бичсэн, дотоод хяналт шалгалт ажилладаггүй, ХБ авч ажиллуулаагүй, цэргийн алба хаасан хугацаа болон нөхөн даатгалтай иргэдийг ажилласан | 2023.01.01 2023.12.01 | 100 хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | жилд нэмээгүй, ахмадын сан байгуулаагүй, өр үүссэн зэрэг зөрчил дутагдал илэрснийг газар дээр нь арилгуулж зөвлөгөө өгч ажилласан. | | |
| 1.2 | **Арга хэмжээ 1.2.** Удирдах дээд байгууллага болон иргэдээс ирсэн өргөдөл гомдлын мөрөөр төлөвлөгөөт бус шалгалт хийх | Тоо хэмжээ | Өргөдөл, гомдлыг хууль, журмын дагуу 100 хувь шийдвэрлэж, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна. | -Иргэн Б.Сүнжидмаагийн өргөдөл гомдлын дагуу газрын даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 07/22-04/113-09 тоот хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу "Нью капитал тэнцэл аудит" ХХК-ний санхүүгийн болон бусад холбогдох баримтуудад хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэв. Хяналт шалгалтаар тус байгууллагад ажил, хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн харилцаа үүсээгүй Б.Сүнжидмааг нийгмийн даатгалд хамруулж тайлагнасан зөрчил илэрсэн. Иймд зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.5-д заасан заалтын дагуу "Нью капитал тэнцэл аудит" ХХК-ний менежер О.Эрдэнэайханд 500,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа.<br>-Засгийн газрын 362 дугаар тогтоолоор "Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм" шинэчлэгдэн батлагдсан. Дүрмийн дагуу аймгийн ЗДТГ-аас санал авч, аймгийн Үйлдвэрчиний холбоо, ажил олгогч эздийн холбооны оролцоотойгоор бүрэлдэхүүнийг шинээр батлуулан ажиллаж байна.<br>Зөвлөл нь 2024 онд 15 даатгуулагчийг өргөдлийг хүлээн авч 6 цуцлаж 9 шийдвэрлэсэн байна. Хөдөлмөрийн нөхцөл тогтоолгох өргөдлийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны а/221 дүгээр тушаалаар баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт"-ыг баримтлан шийдвэрлэн ажиллаж байна. Сумдын "Даатгуулагчийн малчинаар ажиллаж шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл" нь татан буугдсантай холбогдуулан тухайн үүргийг аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх | Жилдээ | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл” хариуцан шийдвэрлэхээр болсон. | | |
| 1.3 | **Арга хэмжээ 1.3.** Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх. | ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнд хяналт тавьж ажиллах, | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан шалгаж, илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны бүрдүүлэлт зарцуулалтанд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар иргэн Г.Энхтүвшингийн үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн байхад энгийн тэтгэвэр тогтоож зөрүү үүсгэсэн тул иргэнд нөхөн олгуулхаар 666400 /зургаан зуун жаран зургаа дөрвөн зуу/ төгрөгийг нөхөн олгуулхаар, сан хооронд шилжүүлхээр 4772580 /дөрвөн сая долоон зуун далан хоёр таван зуун наян/ төгрөг нийт 5438980 /таван сая дөрвөн зуун гучин найм есөн зуун наян/ улсын байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоож ажиллалаа. Биелэлт 100 хувь. | 2024.03.01 2024.12.01 | 100 |
| 1.4 | **Арга хэмжээ 1.4.** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баталсан урьдчилан сэргийлэх 3 удирдамжаар ААНБ-ын эрсдийг үнэлж шалгалт хийнэ. | Уул уурхай, нүүрс тээвэр, барилга угсралт, эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэж буй аж ахуйн нэгж байгууллагууд. | Ажилтны нийгмийн хамгааллын шалгах хяналтын хуудсаар эрсдлийг тооцож үнэлгээ өгнө. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж буй аж ахуйн нэгжүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ. Хяналт шалгалтанд 9 аж ахуйн нэгж хамрагдлаа. “Степ голд” ХХК 17.7, “Хан тамсаг” ХХК 21,4, “Пенин” ХХК 2,9, “Окс лимитэд операторс” ХХК 45,2, “Стэп ийст” ХХК 31,1, “Шинь шинь” ХХК 24,3, “Есүй бэхи” ХХК 39.8, “Ванчин цутгалт” ХХК 15,1, “Тунгуан майнз” ХХК 18,2, “Найнги” ХХК 84,8 тус тус эрсдэл үнэлэгдлээ. Нийтлэг зөрчил: Хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилчдын нөхцлийн кодыг нийгмийн даатгалын тайланд буруу оруулдаг, тушаал шийдвэр хөдөлмөрийн гэрээнд тусгахдаа нэршлийг буруу бичдэг. Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй хөлсөөр ажиллах гэрээ байгуулснаар нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулж тооцдог. Ажилчдын | 2023.05.10 2023.12.01 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажилласан жилийн судалгаа буруу тооцдог. Энэ нь цэргийн алба хаасан хугацаа нөхөн даатгалын хугацааг ажилласан жилд оруулаагүй нь ээлжийн амралт тооцход зөрүү гардаг. Ахмадын сан байгуулаагүй, дэмжлэг үзүүлдэг гэх боловч баримтжуулаагүй. Дотоод хяналт шалгалтыг хийхээ больсон. "Шинь шинь" ХХК нь Хөдөлмөрийн болон бусад төрлийн гэрээ байгуулаагүй ажил хөдөлмөр эрхлэдэггүй хүний нийгмийн даатгалын шимтгэлийг төлдөг зөрчилд зөрчлийн тухай хуулийн дагуу 5,0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. | | |
| | | | | Барилга: Шалгалтад Дорнод аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Доц" ХХК, "Ольхон арал" ХХК гэсэн 2 аж ахуйн нэгж хамрагдлаа. "Ольхон арал" ХХК, "Доц" ХХК зөрчигдөж байгаа асуудал бол өр үүсгэдэг тогтоосон хугацаанд НДШ төлдөггүй, цалин хөлсийг бууруулж тогтоодог, ажилтныг нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллээр хангаж ажиллаагүй, ахмадын сан байгуулаагүй, ахмад настангуудад дэмжлэг туслалцаа үзүүлдэггүй, цэргийн алба хаасан хугацаа болон 1990-1995 оны хооронд нөхөн даатгалын хугацааг ажилласан жилд оруулж тооцдоггүй, ажил мэргэжлийн код буруу сонгосон, хэвийн бус нөхцөлийн код нэршил буруу тогтоосон, МХГ татан буугдснаас хойш дотоод хяналт шалгалтыг зогсоосон зэрэг зөрчил дутагдлууд илэрч байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тээвэр: “Айсвн” ХХК нь “Петрочайна дачин тамсаг” ХХК-тай гэрээгээр тээврийн үйл ажиллагаа эрхлэж байгаад гэрээ дуусаж үйл ажиллагаа зогссон байна. “Айсвн” ХХК нь баар ресторан буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хяналт шалгалтанд хамрагдсан. “Тал нутгын Хэрлэн” ХХК 2015 оноос Улс хооронд Манжуур Дорнодын чиглэлд хүн тээврийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Авто агро ХХК авто замын засвар үйлчилгээ, авто замын барилга, бетон зуурмагны үйлдвэрийг 1998 оноос эхлэн эрхлэж байна. Шалгалтад хамрагдсан 3 аж ахуйн нэгжүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч цаашид давтагдуулахгүй байх хууль зүйн мэдээллийг хүргүүлж ажиллалаа. “Тал нутгын Хэрлэн” ХХК нь урт хугацааны төлөгдөөгүй 12,0 сая төгрөг, “Авто агро” ХХК-ийн 31 сая төгрөгийг хяналт шалгалтын хугацаанд барагдуулуулж ажилалалаа. Шалгалтаар бичиг баримт тушаал шийдвэртэй хамааралтай нийт 33 зөрчлийг газар дээр арилгууллаа.<br>“Авто-агро” ХХК нь 7 ажилчныг нийгмийн даатгалд хамруулаагүй тул Зөрчлийн хуулийн дагуу 500.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилчдыг нийгмийн даатгалд хамрууллаа. | | |
| | | | | ХХАА: 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Дорнод Онон” ХХК “Онхоодой өндөр” ХХК хамрагдлаа.“Шимт газар” ХХК “Дорнын шинэ ургац” ХХК “Хаан хүнс” ХХК “Дорнын цагаан дэрс” ХХК “Талын өгөөж” ХХК “Онхоодой өндөр” ХХК үйл ажиллагаа эрхлээгүй зогссон байна. “Хаан хүнс” ХХК нь илэрсэн зөрчил дутагдалыг шалгалтын явцад арилгаж албан бичгээр баримтжуулан ирүүлсэн.<br>“Онхоодой өндөр” ХХК нь 12,2 сая төгрөгийн өр үүсгэснийг хуваарь гарган төлүүлж байна.<br>Хуулийн хэрэгжилт 53,8 эрсдэл 50,6 үнэлэгдлээ. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | **Арга хэмжээ 1.5.** Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан "Цахим хяналт, шалгалтын ажлын заавар"-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг тогтмолжуулах, | Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналтын веб програм"-(http://10.9.0.5/monitoring)-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж "Цахим хяналт, шалгалтын ажлын заавар"-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | Цахим хяналт, шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн зөрчлийн 80,0 доошгүй хувийг шалгаж, залруулсан байна. | ➢ Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн 01/1107 тоот дотоод хяналтыг сайжруулах ажлын хүрээнд шинэ нэвтэрсэн SICOS системд тэтгэвэр тэтгэмж тогтоолт, олголт зэрэг мэдээллийг оруулхад гарсан алдаа дутагдалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн илэрсэн зөрчлийн газар дээр арилгуулж, танилцуулж ажиллалаа.<br>➢ Төлөвлөгөөт шалгалтын дагуу 13 сумын тэтгэвэр тэтгэмжийн олголтыг нэг бүрчлэн шалгаснаар иргэнд нөхөн олгох 6062115 төгрөг, суутган тооцхоор 2009961 төгрөгийн зөрчлийг илрүүлж ажилласан. | 3 улирал | 100 |
| 1.6 | **Арга хэмжээ 1.6.** Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, салбар, төлөөлөгчийн газар, төлөөний газруудад хяналт шалгалтыг хийлээ. Хяналт шалгалтыг хийхийн тулд Дорнод аймгийн ЗДТГ, Хэрлэн сумын ЗДТГ, Гадаадын иргэн, харьяатын газар, зүүн бүс дэх газар, Улсын бүртгэлийн газар, Татварын газруудаас судалгааг авч ажиллалаа.<br>1. Дэлхийн зөн "Хүүхэд ивээх тэтгэх" хөтөлбөрийн санхүүгийн мэргэжилтэн Э.Энхчимэг нь Улаанбаатар хотоос ирж цаг хугацаандаа хяналт шалгалтад хамрагдсан. Дорнод салбарт 5 ажилтан ажилладаг байна. Ажилчдыг ажилд орсон өдрөөс хөдөлмөрийн гэрээ байгуулж тушаал гаргаж нийгмийн даатгалд хамруулсан байдлыг санхүүгийн баримт нийгмийн даатгалын тайлан, тушаал шийдвэрт тулгуурлан шалгалаа. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг цаг хугацаандаа гаргаж тайлагнадаг, шимтгэлийн өр үүсгэдэггүй ажиллаж хэвшсэн байна. Ажилтнуудад олгосон цалин хөлс түүнтэй адилтгах орлогод ногдох НДШ үнэн зөв | | 50 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тодорхойлж тайлагнадаг байна. Даатгуулагч Г.Ариунзаяа, А.Мөнхжин нарыг ажилд томилсон тухайн сарын хоногт ногдвол зохих нийгмийн даатгалын шимтгэлийг дараа сарын цалинтай нэгтгэж тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг зөрчсөн байна. Иймд тухайн сарын нийгмийн даатгалыг салгаж залруулга мэдүүлэг хийхийг улсын байцаагчийн албан шаардлагаар хүргүүлж ажиллалаа.<br>2. "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" /АДАПТ/ нь 4 аймагт хэрэгжиж байна. Улаанбаатар хот дахь төслийн нэгж дээр нийгмийн даатгалд төлдөг шалгуулах боломжгүй гэсэн албан тоот ирүүлсэн.<br>3. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг" төсөл "дэлхийн зөн Монгол" олон улсын байгууллага нь шалгалтад хамрагдаагүй, Улаанбаатар хотод нийгмийн даатгалд хамрагддаг гэсэн албан тоот ирүүлсэн. Энэхүү төсөл нь богино хугацаанд хэрэгжих тул Дорнод аймгийн ажилтан О.Байгалмаа нь ДЗМОУБ-ын төв газар буюу Улаанбаатар хот Сүхбаатар дүүргийн НД хэлтэст №2023012800501 ажил олгогчийн кодтой тайлагнадаг байна.<br>4. Чойбалсан дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50МВ-аар өргөтгөх төсөлд удирдамж танилцуулж хүргүүлсэн, удаа дараа шалгалтад хамрагдахыг шаардсан боловч шалгуулаагүй.<br>➤ Хяналт шалгалт хийсэн аж ахуйн нэгжид эрсдлийн үнэлгээ хийснээр дотоод хяналт шалгалтын тушаал шийдвэр тайлан мэдээ төлөвлөтийг шалгахад дотоод хяналт суларсан хяналтыг хийхээ больсон нийтлэг зөрчил байгааг арилгуулах заавар зөвлөмж өгч ажилласан. Ингэснээр Засгийн газрын 311 дүгээр тогтоолтын хэрэгжилт сайжирна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ➢ Нийгмийн даатгалын газрын даргын баталсан "Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, авлага барагдуулах аян"-ы удирдамжийн дагуу 6-р багт хуваарилагдан 52-н ААН-ийн 262,250,942.18 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулахаар ажиллалаа. 4 ААН-ийн арилжааны банкан дахь дансыг хаасан. 19 Аж ахуй нэгжийн 40,805,905 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулан ажиллалаа. Сайн дурд шинээр 15 иргэнийг хамруулж ажилласан.<br>➢ НДЕГ-ын нэгдсэн хяналт шалгалтаар Баяндун, Матад, Гурванзагал сумын 2019-2023 оны хугацааны тэтгэвэр тогтоолт олголтыг хянан шалгалаа. Шалгалтаар илэрсэн зөрчилыг танилцуулж, арилгуулах чиглэл өгч ажиллалаа. | | |
| 1.7 | **Арга хэмжээ 1.7.** Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлнэ. | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн хугацаатай удирдамжын дагуу хяналт шалгалтыг хийж хамааралтай албан бичиг боловсруулан гаргаж, заасан хугацаанд хүргүүлж ажиллаж байна. Илэрсэн зөрчил дутагдалд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, , газар дээр зөрчлийг арилгаж биелэлтийг хүлээн авч торгуулийн арга хэмжээ авж ажилласан. | | 100 |
| 1.8 | **Арга хэмжээ 1.8.** Зөрчлийн тухай хууль, | Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, | Зөрчлийн тухай хууль, Зөрчил | Нийгмийн даатгалын тухай хууль шинэчлэн батлагдаж Нийгмийн даатгалын ерөхий хууль | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | хяналт тавих, эрх бүхий албан тушаалтныг томилж тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажиллана. | шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага тооцож, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн торгуулийг 100 хувь, шимтгэл, алдангийг 70-аас доошгүй хувиар барагдуулсан байна. | болсноор холбогдох хууль дүрэм журамд өөрчлөлтүүд орсон. Шинэчилсэн хууль тогтоомжийг нэг бүрчлэн судлан уншиж ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар зөрчилтэй аж ахуйн нэгжид хариуцлага тооцож ажиллаж байна.<br>Аймгийн нутаг дэвсгэрт уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Шинь шинь" ХХК (2830213 регисрийн дугаартай) нь Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.5 "Ажил олгогч нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажил, хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн харилцаа үүсээгүй хүнд шимтгэл төлсөн.." заасан зөрчил үйлдсэнийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 08 цаг 30 минутад илрүүлж, Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтыг үндэслэн 5,0 сая төгрөгийн торгууль ногдуулж барагдуулж ажиллалаа.<br>-"Авто-агро" ХХК нь 7 ажилчныг нийгмийн даатгалд хамруулаагүй тул Зөрчлийн хуулийн дагуу 500.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилчдыг нийгмийн даатгалд хамрууллаа.<br>-Иргэн Б.Сүнжидмаагийн өргөдөл гомдлын дагуу "Нью капитал тэнцэл аудит" ХХК-ний санхүүгийн болон бусад холбогдох баримтуудад хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэв. Хяналт шалгалтаар тус байгууллагад ажил, хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн харилцаа үүсээгүй Б.Сүнжидмааг нийгмийн даатгалд хамруулж тайлагнасан зөрчил илэрсэн. Иймд зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.5-д заасан заалтын дагуу "Нью капитал тэнцэл аудит" ХХК-ний менежер О.Эрдэнэайханд 500,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа. | | 100 |
| ХОЁР. ***Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | **Арга хэмжээ 2.1**. ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийгт 89,1 %-иас дээш биелүүлэх | -Иргэн Б.Сүнжидмаагийн өргөдөл гомдлын дагуу газрын даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 07/22-04/113-09 тоот хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу “Нью капитал тэнцэл аудит” ХХК-ний санхүүгийн болон бусад холбогдох баримтуудад хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэв. Хяналт шалгалтаар тус байгууллагад ажил, хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн харилцаа үүсээгүй Б.Сүнжидмааг нийгмийн даатгалд хамруулж тайлагнасан зөрчил илэрсэн. Иймд зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.5-д заасан заалтын дагуу “Нью капитал тэнцэл аудит” ХХК-ний менежер О.Эрдэнэайханд 500,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа.<br>-Засгийн газрын 362 дугаар тогтоолоор “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм” шинэчлэгдэн батлагдсан. Дүрмийн дагуу аймгийн ЗДТГ-аас санал авч, аймгийн Үйлдвэрчиний холбоо, ажил олгогч эздийн холбооны оролцоотойгоор бүрэлдэхүүнийг шинээр батлуулан ажиллаж байна.<br>Зөвлөл нь 2024 онд 15 даатгуулагчийг өргөдлийг хүлээн авч 6 цуцлаж 9 шийдвэрлэсэн байна. Хөдөлмөрийн нөхцөл тогтоолгох өргөдлийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны а/221 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-ыг баримтлан шийдвэрлэн ажиллаж байна. Сумдын “Даатгуулагчийн малчинаар ажиллаж шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл” нь татан буугдсантай холбогдуулан тухайн үүргийг аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл” хариуцан шийдвэрлэхээр болсон. | | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | **Арга хэмжээ 2.3** Ажил олгогч, иргэд, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 5 удаагийн сургалтад 300 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | | | |
| 2.4 | **Арга хэмжээ 2.4** Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулахаар орон нутагт зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл<br>Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-нд мэдээлэл байршуулсан тоо, хандалтын тоо<br>Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо<br>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, даатгуулагчид, ажил олгогчид мэдээлэл түгээхээр зохион байгуулсан арга хэмжээний төрөл, сурталчилгаа хийсэн тоо<br>Зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгааны 3-аас доошгүй мэдээ, мэдээлэл бэлтгэнэ. | "Дорнод аймгийн нийгмийн даатгал" гэсэн ФБ-д сошил орчинд шинэ мэдээ мэдээлэл оруулсныг хянаж иргэдэд түгээж ажилладаг. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийх бүрдээ албан тушаалтангууд болон ажилчдад хуулийн мэдээ мэдээллийг өгч ажилладаг.<br>Цахим орчинд Нийгмийн даатгалын тухай хуулийг сурталчилж, малчин болон 20 иргэнийг сайн дурд хамруулж ажилалаа. | | |

59

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сурталчилгааны тоо, төрөл | | | | |
| ГУРАВ "ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| 3. 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр тайлагнах. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулна. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан, үнэлүүлсэн байна. | 2023 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийх бүрдээ холбогдох баримт бичиг үйлдэж улиралаар тайлан мэдээнд оруулж ажиллаж байна. НДЕГ ирсэн хариутай бичгийг заасан хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж үр дүнгээ тооцуулан ажиллаж байна. | Жилдээ | |
| 3,2 | Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх | Албан тушаалтны хөрөнгө оруулгын мэдүүлгийг цаг хугацаанд нь гаргаж өгсөн байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх | Төрийн албан хаагчийн ХАСХОМ-ийн тайланг хуулийн хугацаанд нь гаргах үүргийг хэрэгжүүлнэ. | Албан тушаалтны хөрөнгө оруулгын мэдүүлгийг цаг хугацаанд нь гаргаж өгсөн байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ёс зүйн ямар нэгэн зөрчил дутагдал гаргахгүй ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ХАСХОМ-ийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж ажилласан. | Жилдээ | |
| 3,3 | Холбогдох дээд байгууллагаас ирсэн хугацаатай бичгийн хариуг хуулийн хугацаанд гаргаж хүргүүлэх, бусад албан бичгийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллах | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | | Холбогдох дээд шатны байгууллагаас ирсэн бичиг болоод тоо мэдээ удирдамжийн заасан хугацаанд гүйцэтгэн хүргүүлж ажиллаж байна. | Тухай бүр | |
| 3,4 | Удирдлагаас өгсөн хууль ёсны шуурхай үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж ажиллах | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | | Төлөвлөгөөт ажил болон дотоод ажил өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж ажиллаж байна.<br>➢ 156 тэтгэвэр тогтоолтод хяналт хийснээр 7 иргэний тэтгэврийн ажилласан жилийг дутуу болон илүү тогтоосон зөрчлийг илрүүлж | Тухай бүр | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | арилгуулан санд 202835 төгрөг болон иргэнд 21119 төгрөг олгуулж ажиллалаа.<br>➢ Тэтгэврийн цахимжуулах ажлын хүрээнд ӨНТ 361 хувийн хэргийг цахимжуулж ажиллахаас 2023 онд 211, 2024 онд 150 цахимжуулж ажилласан.<br>➢ Онцгой байдлын ерөхий газар Америкийн нэгдсэн улсын зохион байгуулсан "Говийн чоно" сургалтанд 7 хоногийн хугацаатайгаар зохион байгуулалтын ажлын хэсэгт ажилалаа.<br>➢ Монгол улсын Шадар сайдын тушаалаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран "Команд штабын сургууль" сургалтанд хамрагдсан. | |

## ДӨРӨВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | Эхлэсэн, дууссан огноо: |
|---|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | |
| 1 | 2 | 3 | 4 | |
| | "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| 4.1.1 | Танхимын болон онлайн хэлбэрээр сургалтанд хамрагдах | Мэдлэг, ур чадвар дээшилнэ | ➢ 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг гаргаж Шилэн хяналтын системд аж ахуйн нэгж байгуулагын эрсдлыг тогтоож баталгаажуулан ажилласан. Яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүргийн дагуу 2 удаагийн онлайн хуралд оролцож мэдээ мэдээлийг тухай бүр нь авлаа.<br>➢ Байгууллагын дотоод хуралд тухай бүр сууж даргаас өгсөн мэдээ мэдээлэл болоод өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллаж байна.<br>➢ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл"-ын хүрээнд хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагчдыг чадвахжуулах сургалтанд 2024.11.25-26ны хооронд Улаанбаатар хотод сургалтанд хамрагдаж суралцсан. | Жилдээ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | ➢ "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр" Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалт<br>➢ Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, мониторинг хийх арга хэлбэрийг өөрчлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үр дүнд суурилсан үнэлгээ мониторингийн тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газраас болсон сургалтанд хамрагдлаа. | |
| 4.1.2 | Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй болох | | Анхан шатны мэдлэгт суурилж ахисан шатны сургалтанд сууж байна | Жилдээ |
| 4.1.3 | Харилцааны ур чадвараа дээшлүүлэх | | ➢ Харилцааны ур чадвараа дээшлүүлэхэд анхааран ажиллахаас багаар ажиллах чадварыг дээшлүүлж байна.<br>➢ Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан 3 удаагын спортын арга хэмжээнд оролцсон | Жилдээ |
| 4.1.4 | Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжийг бие даан судлах | | Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжийг бие даан судлаж, ажилдаа мөрдлөгө болгож хэрэгжүүллэж удирдах дээд байгууллагад санал хүргүүлж ажиллаж байна. | |

## ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт | Эхэлсэн , дууссан огноо: |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | |
| НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ | | | | |
| 2.2.1 | | | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ ………………… /Г.ЦЭРЭНЖАРГАЛ/ 2024.12.8
*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*